



**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99,  
<http://www.ulaanbaatar.mn>

2020.04.24 № 07/2114

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


**Журмын хэрэгжилтийг хангах  
тухай**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Журам батлах тухай” А/567 дугаар захирамжаар батлагдсан “Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-ыг хүргүүлж байна.

Иймд “Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-ыг хэрэгжүүлж, уг журмын 3.2.7, 4.1.4-т зааснаар шүүх хурлын тов, нэхэмжлэлийн шаардлага, явц, шийдвэрлэлтийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд, шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны нэгдсэн судалгааг хавсралт хүснэгтийн дагуу бөглөж [ub.shuuh@gmail.com](mailto:ub.shuuh@gmail.com) хаягаар 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 8 хуудастай.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА



А.ДАВААЖАРГАЛ

111020001435

2020 ОНЫ .. ДУГААР САРЫН ... НЫ ӨДРӨӨС ... НИЙ ӨДӨР ХҮРТЭЛХ  
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Байгууллагын нэр ..... Огноо.....

д/д	Шүүх хуралдаан болох огноо, цаг минут, / Шүүхийн харьяалал /	Нэхэмжлэгч овог, нэр	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүгчийн нэр	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр	Шийдвэрлэлтийн товч утга	Тайлбар

Тайлан мэдээ гаргасан ажилтны албан тушаал, нэр .....

ОДОО ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭГДЭЖ БАЙГАА ХЭРЭГ,  
МАРГААНЫ НЭГДСЭН СУДАЛГАА

Байгууллагын нэр .....

Огноо.....

д/д	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр	Нэхэмжлэгч овог, нэр	Нэхэмжлэлийн шаардлага	Анхан шатны шүүхийн шүүгчийн овог, нэр	Шийдвэрийн товч утга	Давж заалдах шатны шүүхийн магадлалын товч утга	Ханалтын шатны шүүхийн тогтоолын товч утга	Тайлбар

Судалгаа гаргасан ажилтны албан тушаал, нэр .....

**ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ХЯНАН ШИЙДВЭРЛЭГДЭЖ  
БАЙГАА ХЭРЭГ, МАРГААНЫ НЭГДСЭН СУДАЛГАА**

Байгууллагын нэр ..... Огноо.....

д/д	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр	Хэрэгт холбогдогчийн овог, нэр	Хэрэг бүртгэлтийн хэргийн дугаар, зүйчлэл /аль дүүрэг, хэлтэс тасаг алба/	Байцаагчийн овог, нэр албан тушаал	Хяналтын прокурор шилжүүлсэн эсэх /Огноо/	Анхан шатны шүүхийн шийдвэрийн товч утга	Давж заалдах шатны шүүхийн магадлалын товч утга	Хяналтын шатны шүүхийн тогтоолын товч утга

Судалгаа гаргасан ажилтны албан тушаал, нэр .....



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/367

Улаанбаатар хот

┌  
Журам батлах тухай  
└

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагыг шүүх, хууль хяналтын байгууллагад төлөөлөх үйл ажиллагааны хяналт, бүртгэлийг сайжруулах зорилгоор “Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Шүүх, хууль хяналтын байгууллагад төлөөлөн, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль, журмын дагуу оролцож, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /А.Даваажаргал/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111020002482

## ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар шүүх, хууль хяналтын байгууллагад нийслэлийн нутгийн захиргааны байгууллага/цаашид төлөөлүүлэгч гэх/-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон этгээдийн эрх, үүрэг, ёс зүй, хүлээх хариуцлага, тэдэнд шагнал, урамшуулал олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх нь төлөөлөх байгууллагын эрх бүхий этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үүсэх бөгөөд шүүх, хууль хяналтын байгууллагад төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

1.3 Энэ журмыг Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагууд, харьяа байгууллага, нийслэлийн өмчит төсөвт болон аж ахуйн тооцоот байгууллага, төслийн нэгжүүд дагаж мөрдөнө.

### Хоёр. Төлөөлүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Төлөөлүүлэгч нь холбогдох хууль тогтоомжид заасан болон дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.1.1 Төлөөлүүлэх асуудлын агуулгаас хамааран Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг олгох;

2.1.2 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрхийг тодорхойлох;

2.1.3 Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, төлөөллийг цуцлах;

2.1.4 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нэмж томилох;

2.1.5 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /цаашид Хууль эрх, зүйн хэлтэс гэх/-ийн санал, дүгнэлтийг үндэслэн "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3, 3.4-т заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчид шагнал, урамшуулал олгох;

2.1.6 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөл хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан эрх, үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг шалгах, хуульд заасан хариуцлага тооцох;

2.1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гаргасан хүсэлт, гомдол, саналыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх;

2.1.8 Төлөөлөл хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий өөрт байгаа баримт, мэдээллийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид гарган өгөх.

2.2. Төлөөлүүлэгч нь нэхэмжлэлийг гардан авснаас хойш 5 хоногийн дотор итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон шийдвэр гаргаж хууль, хяналтын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү журмын 2.1.2-т заасны дагуу тодорхойлох итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүрэн эрхэд эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эрх олгохыг хориглоно.

2.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зайлшгүй эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх нөхцөл үүссэн тохиолдолд Хууль, эрх зүйн хэлтэст танилцуулж зөвшөөрөл авсны үндсэн дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчид эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эрхийг тусгайлан олгоно.

Гурав. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүрэг

3.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах эрхийг эдэлнэ.

3.1.1 Олгогдсон итгэмжлэлийн хүрээнд тайлбар, хүсэлт, гомдол, нэхэмжлэл гаргах, төлөөлүүлэгчийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;

3.1.2 Хэрэг маргаанд шаардлагатай нотлох баримтуудыг цуглуулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.1.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тохиолдолд өмгөөлөгч, өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах тухай санал хүсэлт гаргах;

3.1.4 Эрх, үүргийнхээ хүрээнд олж мэдсэн төлөөлүүлэгч болон хуулиар хамгаалагдсан мэдээллийн нууцыг хадгалах;

3.1.5. Хэрэг маргааны оролцогч болон бусад этгээдэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн, урт хугацаагаар сургалтад хамрагдах, эмчилгээ хийлгэх, албан тушаалаасаа чөлөөлөгдөх, өөрчлөгдөх тохиолдолд Хууль, эрх зүйн хэлтэс болон төлөөлүүлэгчдээ урьдчилан мэдэгдэж итгэмжлэгдсэн төлөөлөгч томилуулах хүсэлт гаргах;

3.1.6 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай /нотариатаар гэрчлүүлэх, шүүхэд ирж очих унааны зардал г.м/ зардлыг гаргуулах талаар төлөөлүүлэгчдээ санал тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7 Хэрэг, маргааны явц, түүний шийдвэр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар төлөөлүүлэгч болон Хууль, эрх зүйн хэлтэст 7 хоног тутам тайлагнах, зөвлөгөө, чиглэл авах;

3.1.8 Төлөөлүүлсэн хэрэг, маргаантай холбоотойгоор хүчирхийлэл, заналхийлэл үүссэн бол аюулгүй байдлаа хамгаалуулах санал, хүсэлтийг төлөөлүүлэгч болон цагдаагийн байгууллагад гаргах.

3.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах үүрэг хүлээнэ.

3.2.1 Хууль, эрх зүйн хэлтсийн хариуцсан шүүхийн асуудал хариуцсан мэргэжилтнээс нэхэмжлэлийг хүлээн авч, хуулийн хугацаанд хариу тайлбарыг гаргах;

3.2.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн хувийн үзэл, байр сууринаас хандахгүй байх, улс төр, албан тушаалтны аливаа нөлөөнд автахгүй байх;

3.2.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эвлэрэх зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ журмын 2.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх;

3.2.4 Хэрэг маргааны оролцогч болон бусад этгээдэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэхгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээр нөхцөл байдал үүссэн даруйд төлөөлүүлэгч болон Хууль, эрх зүйн хэлтэст мэдэгдэж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх;

3.2.5 Хэрэг маргааны талаар эрх олгосон албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд болон бусад этгээдэд мэдээлэхгүй байх;

3.2.6 Албан тушаал өөрчлөгдөх, ажлаас чөлөөлөгдөх, итгэмжлэлээс татгалзах зэрэг тохиолдолд өөрт цугларсан нотлох баримтуудыг төлөөлүүлэгч болон дараагийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид хүлээлгэн өгөх;

3.2.7 Хэрэг маргааны явц, шүүх хурлын тов, шийдвэрлэлтийн талаарх мэдээ, тайланг Баасан гариг бүрийн ажлын цаг дуусахаас өмнө Хууль, эрх зүйн хэлтэс /шүүхийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ гарган өгөх;

3.2.8 Шүүхийн болон хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр төлөөлүүлэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд сөргөөр шийдвэрлэгдсэн тохиолдолд давж заалдах, хяналтын журмаар заавал гомдол гаргах;

3.2.9 Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон даруйд Хууль, эрх зүйн хэлтсийн даргад танилцуулж, шүүхийн шийдвэрийг бүртгүүлэх;

3.2.10 Шүүхийн шийдвэр болон хууль хяналтын байгууллагын албан даалгавар, зөвлөмж, тогтоол зэрэг шийдвэрүүдийг хэрхэн биелүүлэх талаар саналаа Хууль, эрх зүйн хэлтэст танилцуулах;

3.2.11 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нотлох баримтыг нь гарган өгөх;

3.3 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч нь заавал биечлэн оролцох бөгөөд хурлаас хоцрох, таслах, хэрэгт ач холбогдол бүхий хүсэлт, тайлбар, нотлох баримт гарган өгөхгүй байх зэргээр үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглоно.

Дөрөв. Байгууллага, эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг

4.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1 Эрхлэх асуудлын хүрээнд шүүх болон хууль хяналтын байгууллагад үүссэн хэрэг, маргаантай холбоотой аливаа асуудлын үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах;

4.1.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай /нотариатын зардал, унааны зардал, өмгөөллийн г.м/ зардал гарсан тохиолдолд холбогдох зардлыг хариуцаж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах нөхцөл боломжоор хангах;

4.1.3 Итгэмжлэгдсэн төлөөлөгч ажил албан тушаал өөрчлөгдөх, ажлаас чөлөөлөгдөх, итгэмжлэлээс татгалзсан тохиолдолд шинээр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилуулах, хэрэг материал, холбогдох нотлох баримтуудыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулах;



4.1.4 Хэрэг маргааны явц, шийдвэрлэлтийн мэдээг сар, улирлаар гарган сар бүрийн 30-ны өдөр, улирлын мэдээг дуусах сарын 25-ны өдрийн дотор Хууль, эрх зүйн хэлтэст тайлагнах;

4.1.5 Итгэмжлэгдсэн төлөөлөгчид шаардлагатай нотлох баримтуудыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4.1.6 Хууль, эрх зүйн хэлтсээс зөвлөмж, чиглэл авах, тавьсан шаардлага өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;

4.1.7 Шүүх, хууль хяналтын байгууллага, эрх бүхий байгууллагаас шаардсан хэрэгт ач холбогдол бүхий баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан тогтоосон хугацаанд гарган өгөх;

4.1.8 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг чадавхжуулах, хуульчийн үргэлжилсэн болон бусад шаардлагатай сургалтад хамруулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

4.1.9 Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор шийдвэрийг сайн дураар биелүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

4.1.10 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажлын амжилт, мэргэжлийн ур чадварыг үнэлж шагнуулах хүсэлт, тодорхойлолтыг Хууль, эрх зүйн хэлтэст гаргах;

Тав. Үнэлж дүгнэх

5.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс улирал тутам итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажлыг үнэлж дүгнэнэ.

5.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажлыг үнэлж дүгнэхдээ ээдрээ төвөгтэй хэрэг маргааныг мэргэжлийн ур чадвар гарган ажилласан, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомж, энэ журмыг хэрэгжүүлэх талаар санал, санаачилга гаргасан зэргийг харгалзан үзнэ.

5.3 Хууль, эрх зүйн хэлтсийн санал, дүгнэлтийг үндэслэн "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3, 3.4-т заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчид шагнал олгоно.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1 Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-д заасны дагуу шалган тогтооно.

6.2 Хууль тогтоомж болон энэхүү журмыг зөрчсөн нь тогтоогдвол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.